



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

ИЛТГЭЛ

*Сэдэв: Цахим хэрэглэгдэхүүнийг ашиглан суралцагчдын идэвх
оролцоог сайжруулах*

Илтгэл бичсэн багш:

Химийн багш } Боловсролын тэргүүний ажилтан, магистр, ахлах
багш:

М. Дэлгэрням

Газарзүйн багш, Боловсролын ухааны магистр, ахлах багш

С.Сүндэрмаа

2022 он

ТОВЬЁОГ

УДИРТГАЛ

- ✓ Судалгааны ажлын зорилго
- ✓ Судалгааны ажлын зорилтууд
- ✓ Судалгааны ажлын үндэслэл
- ✓ Судалгааны аргууд
- ✓ Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол
- ✓ Дэвшүүлэх буй санаа

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ОНОЛ АРГА ЗҮЙ

1. Цахим хэрэглэгдэхүүн гэж юу вэ?
2. Цахим хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага
3. Цахим хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй

ХОЁРДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1. Багш нараас авсан судалгааны хэсэг
2. Суралцагчдаас авсан судалгааны хэсэг
3. Туршилт судалгааны хэсэг

Дүгнэлт

Ном зүй

Оршил

Дэлхий нийтийг хамарсан цар тахал гарсантай холбоотой 2019-2022 оны хичээлийн жилүүдэд цахим сургалт зохион байгуулсан нь сургалтын чанар үр дүнд нөлөөлж байгаа бөгөөд цахим сургалтыг зохион байгуулах, арга зүйг суралцаж зайлшгүй шаардлага гарч байна.

Үндэслэл: Цахим сургалтыг зохион байгуулаад 3 жил болж байгаа бөгөөд сургалтын агуулга стандартыг хангахад нэлээдгүй хүндрэл учирч ялангуяа цахим хичээлийг зохион байгуулах сургалтын арга зүй, суралцагчийн оролцоо, идэвх сонирхолыг татах, нэмэгдүүлэхэд багш, суралцагчийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд цахим хэрэглэгдэхүүн боловсруулсан суралтандаа ашиглах нь чухал байна.

Зорилго: Цахим хэрэглэгдэхүүнийг ашигласнаар цахим сургалтыг үр дүнтэй зохион байгуулан [суралцагчдын идэвх, оролцоог дэмжих, нэмэгдүүлэх

Зорилт:

- Цахим хэрэглэгдэхүүнийг боловсруулах ашиглах онол арга зүй талаар танилцуулна.
- Цахим хичээлийн хэлбэр, зохион байгуулалт, үе шат, ашиглаж буй хэрэглэгдэхүүн, суралцагчдын оролцоо, идэвхийн талаарх судалгаа, өнөөгийн байдалд дүгнэлт гаргана.
- Цахим хэрэглэгдэхүүнийг суралтандаа ашигласан байдал, түүний үр дүн, ач холбогдол

Дэвшүүлж буй санаа

Цахим хэрэглэгдэхүүнийг ашигласнаар суралцагчийн идэвх оролцоо нэмэгдэн сургалтын үр дүн сайжирна.

Судалгааны арга

- Мэдээлэл түгээрэх, эх сурвалжийн анализын аргыг сэдвийн судалгаасан байдлыг тогтоож онолын хэсгийг боловсруулах
- Хэлэлцүүлэгийн аргыг багш сургалтын цагийг багц цагаар тооцоход тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замүүдийг тодорхойлох
- Ажиллалтын аргаар багшийн цахим хичээл зохион байгуулж байдал, суралцагчийн оролцоо идэвхийг явцыг мэдэх
- Статистик боловсруулалтын аргыг цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийхэд тус тус хэрэглэв.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ОНОЛЫН ХЭСЭГ

ЦАХИМ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН ГЭЖ ЮУ ВЭ?

Хэрэглэгдэхүүн гэж юу вэ?

Хэрэглэгдэхүүн гэдэг нь сургалтын салшгүй нэгэн хэсэг бөгөөд тухайн хичээлийг амжилттай болгох бүхий л нөхцлийг хангадаг зүйл юм.

Цахим хэрэглэгдэхүүн гэж юу вэ?


Сургалтын дидактик шаардлагад нийцэхүйц боловсруулагдсан, компьютер болон бусад технологийн тусламжтайгаар сурагчдад хүрч, сургалтанд хэрэглэгддэг нэгэн төрлийн хэрэглэгдэхүүн бол цахим хэрэглэгдэхүүн юм. Өөрөөр хэлбэл:

Цахим сургалт = технологийг суурилсан сургалт

Цахим сургалтын томъёолол:

Энэ нь компьютерт суурилсан сургалт, вэб суурилсан сургалт, виртуал сургалт, төлөвиз радиогийн сургалт зэргийг агуулах сургалтын нэгэн шинэ хэлбэр бөгөөд үйлчилгээний өргөн цар хүрээг агуулсан байдаг.

Цахим сургалт нь сурагчдад агуулгаа хүргэхдээ бүх төрлийн цахим дамжуулах төхөөрөмж, түүний дотор интернет, хиймэл дагуулийн систем, аудио, видео систем зэргийг ашигладаг.



Цахим хэрэглэгдэхүүнд тавигдах хэд хэдэн үндсэн шаардлага байдаг.

Үүнд:

1. Түлхүүр буюу гол ойлголтоо оновчтой тодорхойлох.
2. Өнгөний зохицолтой байх.
3. Хөдөлгөөний эффект бүхий зураг, схем өргөнөөр ашиглах.
4. Суралцагчийн идэвхи оролцоог тооцож боловсруулах
5. Хичээлээ нэгтгэн дүгнэдэг байх.

Үүнээс гадна цахим хэрэглэгдэхүүний элементүүдэд тавигдах шаардлага гэж байдаг. Үүнд:

Дд	Шаардлагын нэр	Шаардлага
1.	Дуу авианд тавигдах шаардлага:	- Хэт өндөр давтамжтай биш байх. - Дууны давтамж нэгэн хэвийн уйтгартай биш байх. - Энгийн ойлгомжтой, нуршуу биш байх. - Дуу авианы тусламжтайгаар чухал гэсэн ойлголтуудыг тайлбарласан байх.
2.	Зурганд тавигдах шаардлага:	- Тухайн сэдвийн агуулгатай сайтар уялдсан байх. - Хэлж буй санаагаа хамгийн товчоор илрхийлсэн байх. - Өнгө, түүний сонголт, харагдах хэмжээ нь зөв төлөвлөгдсөн байх.
3.	Хөдөлгөөнт дүрсэд тавигдах шаардлага:	- Тухайн объектод хөдөлгөөн оруулж өгснөөр төлөв байдал нь илүү сайн илэрхийлэгдэхээр байх. - Өнгөний зохицол болон сонголт, харагдах хэмжээ нь зөв төлөвлөгдсөн байх. - Дүрсийн хөдөлгөөнийг удирдаж болдог байх.
4.	Видео бичлэгт тавигдах шаардлага:	- Тухайн сэдэв, чиглэлтэйгээ нарийн тохирч байх. - Дүрс бичлэг нь чанартай байх. - Дуу авианы хувьд шаардлага хангасан байх.
5.	Нэг хуудсанд тавигдах шаардлага буюу	- Зураг, видео зэрэг материал хичээлийн тексттэй зохицсон байх. - Хичээлийн текстийг дэлгэцэнд бүтнээр нь багтаасан байх.

	бэлгэцүүн зохиомжлол:	- Текстийн хэмжээг 5-8 мөрөөр хязгаарлаж, нэг дэлгэцэнд 15-аас дээш мөр оруулахгүй байх - Текстийг мөрний уртаар хязгаарлаж, 10 хүртлэх үгийг нэг мөрөнд багтаахыг хичээсэн байх. - Дэлгэцэнд дэх текстэнд 2-оос илүү парараф холихгүй байх.
--	------------------------------	--

Сургалтын цахим хэрэглэгдэхүүн нь нэг талаасаа сургалтын оновчтой аргыг сонгон тухайн насны хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон бөгөөд хэрэгцээ шаардлагад тулгуурласан шавь төвтэй байх нөгөө талаасаа суралцагч бие даан суралцах бүхий л боломжийг олгодог байх хэрэгтэй.

Сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй:

Сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулахад маш их хэмжээний цаг, хүч, хөдөлмөр шаардагддаг. Өөрөөр хэлбэл уламжлалт сургалттай харьцуулахад 80%-ийн бэлтгэл шаардагддаг учраас дараах үе шатын даруу төлөвлөж боловсруулах хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл дээрх арга зүйг нарийвчлан авч үзвэл:

Дү	Үе шат	Ажлудын үе шатыг жагсаалт 1. Төлөвлөгөө боловсруулах Хэрэглэгдэхүүнийхээ хэлбэрийг тодорхойлох. Ашиглах орчноо тодорхойлох. 2. Хэрэглэгдэхүүний төлөвлөлт хийх Үдирдлагын схемийг сонгох. Слайдудын дизайныг боловсруулах. 3. Мэдээлээ цуглуулах Слайдыг боловсруулахад хэрэглэгдэх материалыг цуглуулах. Дуу авианы хавсралтыг бэлдэх. Бедно хавсралтыг бэлдэх. Аудио, видео, хөдөлгөөнт файлууд болон бусад график файлуудыг бэлдэх. 4. Хэрэглэгдэхүүн бэлдэх Мэдээлэн материалуудаар танилцуулгын слайдуудыг бэлтгэх. Слайдын өнгөний хослолыг тохируулах, дизайныг шийдлийг гаргах. Хөдөлгөөн оруулах. Үдирдлагын бүтцэд цэсний элементүүдийг оруулах. 5. Шалгах Текстэн болон үзүүлэн таниулах материал дахь алдаануудыг засварлах. Эффект, хөдөлгөөнийг шалгах. Үдирдлагын элементийн ажиглалааг шалгах.
-----------	---------------	--

6.	Түрших	Хичээлд хэрэглэх.
7.	Хөгжүүлэх	Хэрэглэгдэхүүнийг сайжруулах, засварлах.

Сургалтын цахим хэрэглэгдэхүүнийхээ төслийг боловсруулах алхам:

Цахим хэрэглэгдэхүүн боловсруулахдаа агуулгын аль хэсэгт, ямар элементүүдийг хэрэглэхээ дэлгэц бүрээр нарийн төлөвлөх шаардлагатай байдаг. Үүнийг дараах алхмуудаар боловсруулна.

1. Зорилго, зорилтгоо нарийвчлан тодорхойлох.
2. Материал цуглуулахдаа:
 - Цогц чадамж харгалзах.
 - Хүлээгдэж байгаа үр дүнг нарийн гаргаж тодорхойлох.
3. Агуулгын хүрээг тогтоож, арга зүйгээ боловсруулахдаа:
 - Агуулгын хүрээг бүрэн сэдвээр гаргах.
 - Дидактик боловсруулалт хийх.
 - Сэдвүүдэд хуваах.
 - Цогц чадамжийг төлөвшүүлэхэд анхаарах.
4. Тухайн ухагдахуун бүрийн хувьд түүнийг илэрхийлэх дидактик шийдлийг олох.
 5. Үнэлгээний элементийг төлөвлөхдөө:
 - Аль хэсэгт ашиглахаа төлөвлөн нарийн заах.
 - Хамрах хүрээг тогтоох.
 - Үнэлгээний ямар хэлбэрийг ашиглахаа тодорхойлох.
 6. Дизайны зохиомжийн дидактик шийдлийг бий болгохдоо:
 - Цахим хэрэглэгдэхүүн бэлдэх зөвлөмж ашиглах
 - Дизайнны зохиомжийн шаардлагыг хангах

Цахим хэрэглэгдэхүүн боловсруулах үе шат:

Энэ үе шат нь өмнөх шатанд боловсруулсан төслийн дагуу цахим хэрэглэгдэхүүнээ компьютерт боловсруулах үе шат юм. Хэдийгээр хэрэглэгдэхүүнийг боловсруулах төслийг өмнөх алхамд хийсэн боловч энэ алхамд дидактик шийдэл хийх шаардлага байсаар байдаг. Тухайлбал, өнгөний зохицол, дэлгэцийн зохиомж гэх зэрэг асуудлыг энэ алхам болон дараагийн алхамд шийдэж болдог.

Мөн цахим хэрэглэгдэхүүн нь дидактик боловсруулалтаас гадна сургах программын шинжийг агуулсан байх шаардлагатай бөгөөд боловсруулж байгаа программынхаа талаар мэдлэгтэй байх хэрэгтэй. Энэ үүднээс сонгон судлаж байгаа Microsoft Office – ийн PowerPoint программын цэснүүдийн өргөн хэрэглэгдэх командын үүргийг сайн мэдэх шаардлагатай.

Суралцагчийг цахим хэрэглэгдэхүүнээр үнэлэх аргазүй:

Хичээлд суралцагчийг үнэлэх цахим үнэлгээний систем ашиглах нь нэг хэвийн байдлаас нь гаргаж цааш хөгжих, судлах сэдэл төрүүлдэг давуу талтай байдаг. Нөгөө талаас багш өөрийн суралцагчийн мэдлэгийн түвшин, сурах явцын талаарх мэдээлэл олж авахад чухал үүрэгтэй.

Цахим суралтын шалгалтын материалыг бичгээр харуулах, сонсоод харуулах, уншаад харуулах, нэг зөв харуулттай сонголттой харуулт, олон зөв харуулттай сонголттой харуулт, харгалзуулах, зөв/буруу-г олох, хоосон зайг бөглөх зэрэг олон төрлийн сонголттойгоор бэлтгэж болдог.

Суралтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулахад өргөн ашиглагдаж байгаа програмууд нь:

Movie Maker, PowerPoint, Flash, Audacity, Camtasia, Snagit, iSpring, Articulate Studio... гэх мэт.

Power Point програм нь үзүүлэн бэлтгэдэг програм тул нийт сурагчдын дунд cambar дээр шалгалтын материалыг гаргаж байгаад авах, мөн харуултыг эргэн хамтран ярилцахад хамгийн тохиромжтой програм юм.

Power Point програм ашиглан суралтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах нь:

Power Point програм нь Microsoft office компанийн гаргасан шилдэг програм хангамжуудын нэг бөгөөд цахим хэрэглэгдэхүүн боловсруулахад хамгийн өргөн ашиглагддаг. Энгийн, сурахад хялбар программ юм.

Энэхүү програмын үндсэн зорилго нь танилцуулга, илтгэл, лекц ярианы үзүүлэн таниулах материал бэлтгэх, тэдгээрийг тунгалаг хальс, бичгийн цаас, слайдад буулгах болон компьютерийн дэлгэц дээр гаргах, эдгээртай холбогдсон тэмдэглэл хийх боломжийг олгох юм.

Туршилт, судалгаа:

Өөрийн боловсруулсан хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүйгээ туршиж бусдад хэр ойлгомжтой, цаашид хэрэглэхэд мөн хөгжүүлэхэд ашиглагдах үгүйг нь мэдэх зорилгоор жишээ хичээлийг өрөнхий боловсролын сургуулийн 4 багш болон 24 сурагчтай хамтарч боловсрууллаа.

Туршилтын хүрээнд хамтран ажилласан багш сурагчид хэрэглэгдэхүүнийг зааврын дагуу уншиж 1.42-2.28 минут хийж гүйцэтгэсэн. Хэрэглэгдэхүүн бэлдэхэд хэр их хэмжээний цаг хугацаа шаардагддаг нь эндээс харагдаж байна.

Боловсруулалт хийх явцад англи хэлний мэдлэг багатай хүмүүст зарим зүйл хүндрэлтэй байсан..

Мөн цаашид энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийхдээ цөм агуулгыг хамрах цөөхөн хуудастай хэрэглэгдэхүүн бэлтгэх хэрэгтэй гэдгийг мэдэж авлаа.

Цахим хэрэглэгдэхүүн ашиглаж илтэл тавих гэж байгаа хүнд өгөх

зөвлөгөө:

1. Балтгасан хэрэглэгдэхүүн товч бөгөөд тодорхой байх ёстой учраас юу прихаа маш сайн төлөвлөх хэрэгтэй.

2. Балтгасан үзүүлэлтээ илтгэлд сууж байгаа хүмүүстээ тарааж өгөх хэрэгтэй. Учир нь таны балтгасан слайдыг унших гээд, эсвэл харах, тэмдэглэх гээд таны ярианд тэр болгон анхаарал хандуулахгүй байх талтай.

3. Хүний нүд бүрэлзүүлэх фон өнгө бүр сонгоорой. Мөн текстийг хэтэрхий уусалттай бүү бичээрэй. Хүмүүсийн сонирхол буурна.

4. Бусдад бодох, эргэцүүлэх цаг хугацааг оновчтой төлөвлөж өгөх хэрэгтэй.

5. Хамгийн чухал хэсгүүдээ тодруулж, дэлгэрүүлж байх хэрэгтэй.

6. Төлөвлөгдөөгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, урьдаас таамаглах зэргээр бэлгэлийг хангаж тавьсан асуултанд оновчтой хариулах.

7. Цахим хэрэглэгдэхүүнээ хэрэглэхийн өмнө ямалт хянаж байх. Ингэснээр бусдын өмнө эвгүй байдалд орох зэргээс урьдчилан сэргийлж чадна.

8. Мөн илтгэлээ тавихын өмнө компьютерийн цэнэг, хананд тусгах байдал, проекторын тусгалыг тооцоолж байх хэрэгтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ХЭСЭГ


1.Батш нараас авсан судалгаа

Сургуулийн батш нараас 4 асуулгаар санал авахад

1.Та цахим хэрэглэгдэхүүн бэлтгэдэг үү?

10 % үгүй, 90 % боловсруулдаг ба цахим гэрийн даалгавар, видео бичлэг, зураг,Цахим тест боловсруулдаг гэж хариулсан байна. Иймд хэрэглэгдэхүүний нэр төрөл, боловсруулах арга зүйд сурагцах шаардлагатай байгааг харуулаж байна.


1.ТА ЦАХИМ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БЭЛТГЭДЭГ ҮҮ?




2.Цахим хичээлдээ ямар хэрэглэгдэхүүнийг ашигладаг вэ?

Асуулгад 22 батш хамрагдсан ба нийт батш нарын 72% PDF, Powerpoint 10%, Онлайн хичээл 5%, Бусад 4%

2. ЦАХИМ ХИЧЭЭЛДЭЭ ЯМАР ЦАХИМ ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙГ АШИГЛАДАГ ВЭ?






Хэрэглээний программ 90% , Canva, Cantasia 54,5%, Prize, Photoshop, Genially 10%, Adobe captivate 10% ашиглаж байгаа нь дутмаг, илүү их олон программ дээр ажиглаж, судлах шаардлагатай байна.

4.Цахим хичээл зааж байх явцаа сурагчдыг хэрхэн идэвхжүүлэж оролцоог дэмжиж байна вэ?

Судалгаанаас харахад 90% нь харицан ярицлагыг аргыг сонгож сурагчдаа хэрэглэж байна. Хичээлдээ 64% нь асуулт асуух, видео бичлэг үзүүлэх, 27% нь кейс болон цахим даалгавар дээр ажиглуулах нь хангалтгүй байна. Иймд цаашид цахим хичээлдээ сурагчдын идэвхи оролцоог дэмжих тал дээр анхаарч, цахим хэрэглээний нэр төрлийг олшруулах, сурагчдын бие даах чадвар, бүтээлч байдлыг дээшлүүлэх шаардлагатай байна. Цахим хэрэглээний бодит, дуу дүрсэй, хөдөлгөөнтэй байх нь тлүү үр дүнтэй байна.

4.Цахим хичээл зааж явцдаа суралцагчдыг хэрхэн идэвхжүүлж, оролцоог дэмжиж байна вэ?



Дээрх судалгаанаас үзэхэд багш нарын хувь нь ашиглаж байна.

Цахим хэрэглэгдэхүүн нь дараах давуу талуудтай

- Цаг хугацаа хэмнэнэ
- Эдийн засгийн хэмнэлттэй
- Засах сайжруулах боломжтой
- Багшийн бичиг цаасны ажлыг хөнгөвчилнө.
- Бага хугацаанд их мэдээлэл өгнө.
- Дасгал даалгаварын хариулт, тайлбарыг шууд авах боломжтой
- Суралцагчид мэдээлэл цуглуулах
- Бие даан суралцах

2.Хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулсан баримт судалгааны хэсэг

А. 2019 онд сургалтын үйл ажиллагаа цахим хэдбэрт шилжихэд багш нарын хичээл заах үйл ажиллагаа, суралцагчдын хичээлдээ хандаж байгаа байдалд дүгнэлт хийж багш нарын дунд "Цахим хичээлийн үр дүн түүнийг сайжруулах" "сэдвээр цахим хэлэлцүүлэг хийсэн ба нийт суралцагчдын 80 аас дээш хувийн тандалттай 46,8 %, 50 доош хувийн тандалттай 40,4 хувьтай байгаа нь хамрагдалт хангалтгүй байгаа нь харагдаж байна.

А. Цахим хичээлийн тандалтын судалгаа /2020 оны 11 сар, 12 сарын байдлаар/

		11 сард										12 сард																															
Алгч	Суралцагч ийн тоо	Оруулсан хичээлийн тоо	Суралцагчдын тандалт	Агуулгын тандалт	Дундаж	80 дээш суралцагчийн тандалттай хувийн суралцагчийн тандалттай хувь	50 дээш хувийн суралцагчийн тандалттай хувь	Дээдсээр хийсэн суралцагчийн тандалттай хувь	Оруулсан хичээлийн тоо	Суралцагчдын тандалт	Агуулгын тандалт	Дундаж	80 дээш суралцагчийн тандалттай хувийн суралцагчийн тандалттай хувь	50 дээш хувийн суралцагчийн тандалттай хувь	Дээдсээр хийсэн суралцагчийн тандалттай хувь																												
УУНСО 1а	15	37	333	9	53.30%	33.30%	6 /40 хувь	34	306	9	46.60%	40%	6.40хувь	А3 1а	15	19	190	10	46.60%	20%	4/26.6	17	170	10	30%	26%	4 хүүхэд 26 хувь	71%	17	36	324	9	64%	53%	82%	22	198	9	47%	52%	3 хүүхэд 38%	86%	
ХИММО 2а	17	36	324	9	64%	53%	82%	22	198	9	47%	52%	71%	Тангуйр 2а	8	21	126	6	38%	62%	38%	12	60	5	38%	63%	3 хүүхэд 38%	86%	Тангуйр 2а	8	21	126	6	38%	62%	38%	12	60	5	38%	63%	3 хүүхэд 38%	86%
УУНХАТ 2а	14	22	264	12	86%	14%	86%	12	120	10	79%	21%	86%																														


2020 оны 12 сард хийсэн цахим хичээлийн үр дүн сэдвээр багш нарын дунд цахим хэлэлцүүлэг хийсэн байдлаас харахад

1. Суралцагчдын хичээлд хамрагдалт 40,5 %
2. Хичээл даалгавар хийсэн байдал 50% хувьтай байсан.
3. Багш нарын цахим хичээл бэлтгэсэн байдалд дүн шинжилгээ хийхэд багш нарын 70% нь word pdf файл болгон ашигладаг. Мөн 10 хувь нь РР хичээл, видео, төлө хичээл ашиглаж байсан .


Тус хэлэлцүүлгээс цаашид цахим хичээлийн материалыг боловсролгүй болгох, Google Meet ээр орох, суралцагчдын тандалтанд хяналт тавих, сургалтын алба багш нарын хичээлд хяналт тавих гэсэн дүгнэлт гарч байсан.

Цахим хичээлийн тандалтын судалгаа





- Барш М.Баярмаагийн цахим хэлэлцүүлэгт бэлтгэсэн судалгаанаас барш нарын оруулсан хичээлийн хэрэглэгдэхүүн нь
- Word-73
 - PowerPoint-58
 - Excel-1
 - PDF-251
 - Зургалт хуудас-31
 - Видео-43
 - Аудио-0
 - Бусад-75
 - Хамгийн их хичээл оруулсан-11
 - Хамгийн бага хичээл оруулсан-16



Багш нарын бэлтгэсэн хичээлийн хэрэглэгдэхүүнд :

- Зураг тайлбар / англи монгол /
- Орчуулга /англи монгол /
- Даалгавар, дасгал ажил
- Гарчиг текст хичээлийн ерөнхий агуулга орсон 2-3 хуудас байхад 50-55 хуудастай байна.
- Гарчиг, агуулга, зурагт хуудас, дасгал ажил, гэрийн даалгавар
- Багш өөрийн хийсэн видео бичлэг
- PPT хичээл нь том текст олон хуудас
- Дадлага хичээлийг видео бичлэг, эд анги дээр харуулсан
- Ихэнх PDF хичээл нь Word-н файлыг хөрвүүлж тавьсан байлаа.

Давуу тал	Сул тал
-Зураг, схем ашиглах -Өөрийн хийсэн видео хичээл -Бэлэн цахим хичээл -Цөөн хуудас -Даалгавар, дасгал ажил тодорхой -Гэрийн даалгавар, бие даалт өгөх -Эмх цэгцтэй -Өнгө үзэмж сайтай -Тогтмол хичээл оруулах	-Маш олон хуудас -Нэг нүүр дүүрэн текст -Гэрийн даалгавар, дасгал ажил байхгүй -Эмх цэгцгүй -Хааяа хичээлээ оруулах -Шинэ программ ашиглахгүй -Суралцагчидтай амьд харилцаа байхгүй -Бататгал хичээлгүй -Тамгатай зураг буюу оюуны өмч

2019 оны цахим хичээлийн хэрэглэгдэхүүн, сургалцагчдын хандалтын байдал 2022 оныхтой харьцуулбал ахиц байгааг харж болно.

Б. Сургалт зохион байгуулах

2021-2022 оны хичээлийн жилд танхим, цахим хосолсон сургалтын үйл ажиллагааг зохион байгуулан цахим хичээлийг Google meet -ээр зохион байгуулдаг болсонтой холбоотой багш суралцагчийн харилцаа үүсэх алхам болсон.

2022 оны 10 сард багш монгол хэл уран зохиолын багш Шинэбаяртай хамтран “Цахим хичээлийн төлөвлөлтийг сайжруулах” цахим сургалт зохион байгуулсан ба түүнд хичээлийн сэдэлжүүлэх, бататгах дүгнэх, үнэлэх

хэсэгт тохирсон сонирхолтой программүүдийг ашиглаж талаар багш Н. Шинэбаяр багш танилцуулж мэдээлсэн .

Цахим хичээлийг уулзалтаар анги, анхид зохион байгуулдаг болсонтой холбоотой хичээлийн төлөвлөлт үе шатыг хэрхэн гаргаж байгааг дүгнэлт гаргаж хичээлийн сэдэвлжүүлэх, мэдлэг олгох, дүгнэх, үнэлэх үе шатыг цахимаар хэрхэн зохион байгуулах талаар ярилцан өөрийн туршлагаасаа багш хуваалцсан . Ажиглалтаас багш нар шууд уулзалт хичээлийг ихэнхдээ лекцийн аргаар мэдээлэл шууд дамжуулан хүргэж байгаа бөгөөд хичээлийн үе шатыг гаргахгүйгээр ярилцлагын аргыг ашиглаж байгаа нь харагддаг.

Харин цахим хэрэглэгдэхүүнийг ашиглаж байгааг харахад багш нар харилцан адилгүй програм дээр бэлтгэсэн хэрэглэгдэхүүн ашигладаг.

3 . Сурагчдаас ажиглалтын ярилцлагын аргаар судалгаа авлаа.

Нийт 9 сурагчаас түүврийн аргаар утсаар 3 асуулт асууж цахим хичээлийн талаарх судалгаа авлаа. Үүнд

1. Цахим хичээлээс мэдлэг авдаггүй
2. Мэргэжлийн хичээл сонирхолтой.
3. Хүүхдийн оролцоо муу байдаг
4. РР файл үзүүлдэг.
5. Заримдаа асуулт тавьдаг
6. ТВ хичээл үзүүлдэг.
7. Өрсөн материал нь үзүүлж байхад гацдаг
8. Хийгээрэй гээд гараад явдаг
9. Харилцан ярилцдаг.

Багш нар цахим хичээлийг зохион байгуулахдаа бичүүлж, уншуулж уламжлал аргаар ороход хүүхэд сонирхолгүй анхаарал муу байдаг байна. Цахим хэрэглэгдэхүүнийг бодит, дуу дүрсэй хөдөлгөөнтэй байх нь илүү ой тогтоол, анхаарал, сонирхолтой болгож байна.

4.Гзарзүйн багш С.Сүндэрмагийн бэлтгэсэн цахим хэрэглэгдэхүүнээс

Гзарзүйн хичээлийн 6 сэдвийн хүрээнд 6 цахим хэрэглэгдэхүүнийг бэлтгэж 2-р курсын 6 ангийн группд байршуулан 100 сурагчагчдаас 60 оюутан давтагдсан тоогоор даалгаварыг хийж гүйцэтгэсэн байна. Иймд оюутнуудын идэвхи оролцоо сайжирсан.

Бие даалтын ажлаар сурагцагчид өөрсдөө "азарзүйн хичээлийн агуулгын хүрээнд цахим хэрэглэгдэхүүн боловсруулж мэлгээ батгаж байна.



Ердийн хичээл

- Зарим хичээл их залуутай
- Ойгоход удаан
- Хүүхэд бүрийн оролцоотой
- Хичээл хийлгүй үлддэг сурагч олон
- Хүүхэд бүрийн анхаарал төвлөлт муу
- Товчлол тэмдэглэл их хийдэг
- Сурагчид хичээлдэггүй
- Зардал ихтэй
- Цаг хугацаа их шаарддаг

Цахим хичээл

- Их мэдээллийг бага хугацаанд олж авдаг
- Хүүхдэд илүү сонирхолтой байдаг
- Ойгожтой эргэн санахад илүү амархан
- Гол санааг товч тэмдэглэж авахад хялбар
- Дүү, дүүрс, хөдөлгөөн, өнгөний бичиг цаас овоорхгүй
- Ажлыг хөнгөвчилнө
- Алдаатай үед засаж сайжруулах бүрэн боломжтой

Дүгнэлт

7 Судалгаанаас барш нарын 63 хувь нь цахим хичээлийн хэрэглэгдэхүүн нь дуу дүрс бүхий видео, зураг, дүрс ашиглан сайжирч байгаа ч арга зүйн хувьд харицан ярицах бичүүлэх уншуулах зэрэг уламжлалт аргаар хичээл заахад сонирхолгүй, анхаарал сул байдаг ба цахим хэрэглэгдэхүүнийг боловсруулахдаа илүү оновчтой програм ашигласнаар, бичиг цаасны ажлаа хөнгөвчлөх, эдийн засгийн хувьд хэмнэлттэй, засаж сайжруулах, бага хугацаанд их мэдээлэл өгөх хичээлийн агуулга, юмсыг бодитоор дуу дүрс хөдөлгөөнтэй харуулах нь ой тогтоолтой, үр дүнтэй, сонирхолтой байдаг мөн сурагчдад цахим орчинд ухаалаг хэрэглээнд сурах тэдэнд цахим хэрэглэгдэхүүн хийх аргыг зааснаар мэдээлэл цуглуулах, дасгал даалгавар хийх, мэдлэг шалгах сорил бэлтгүүлж сурах нь сурагчдайн идэвх оролцоог нэмэгдүүлж бүтээлч үйл ажиллагаанд суран сурагчийн үр дүнг сайжруулах чухал алхам болж байна.

Дэвшүүлж буй шинэ санаанууд

- ✓ Цахим хэрэглэгдэхүүний боловсруулах арга зүйд сурагчад
- ✓ Өөрийн хичээлийн онцлогт тохирсон программ сурах
- ✓ Сурагчдайн цахим орчинд ухаалаг хэрэглээнд бие даан сурагчдад арга суран цахим даалгавар судалгаа, бие даалгыг эрэл хайгуул хийлгэсэн даалгаварыг онлайнаар өгч идэвх оролцоог сайжруулах
- ✓ Суруулийн ухаалаг самбарыг ашиглах, өндөр хурдны интернетэй байх

Ном зүй

- 1.Интернет “Цахим хэрэглэгдэхүүн “ илтгэл
2. Ичинхорлоо „Сурган хүмүүжүүлэх арга,, УБ 2002 он
3. МСҮТ-ийн удирдлага, Багш нарт зориулсан мэргэжлийн боловсрол сургалтын талаар хууль тогтоомжийн эмхтгэл УБ 2010 он
4. Интернетээс авсан илтгэлүүд
- 5 „Багшийн хөгжил, ур чадварыг үнэлэх арга зүй „Д.Лхагвасүрэн
9. Бүрэн дунд боловсролын ахлах ангийн цөм хөтөлбөр